



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/869

Ховд

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны  
үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх  
арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/05 дугаар тогтоолын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 1 дүгээр хавсралтаар, "Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн сум, байгууллагатай холбогдол бүхий заалтуудыг хяналтад авч, бүх шатны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусган хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг жилийн эцсийн байдлаар тооцон 11 дүгээр сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, биелэлт, үр дүнгийн мэдээллийг жил бүрийн 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, хэрэгжилт удаашралтай заалтуудыг хяналтанд авч, эрчимжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Д.Ариунбилэг/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.4231  
D/Zah-A/869-Bo